



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 4/873

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Баатархайрхан багийн Барилгачдын 5 дугаар гудамжны 511 тоотод байрлах Менепийн Айбол /ПЭ87051814/-ийн үйлдвэрлэлийн зориулалттай 29132.0 метр квадрат газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Төлөгөний Анна /ПВ86021501/-д 3128 метр квадрат газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, Барилгачдын 5 дугаар гудамжны 511 а тоот болгон 8 жилийн хугацаагаар, 2542 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Раунгулийн Берик /ПЮ97061936/-д гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, Барилгачдын 5 дугаар гудамжны 511 в тоот болгон 8 жилийн хугацаагаар, 2402 метр квадрат газрыг Менепийн Айбол /ПЭ87051308/-д үйлчилгээний зориулалтаар Барилгачдын 5 дугаар гудамжны 511 б тоот болгон, үлдсэн 21058 метр квадрат газрыг Менепийн Айбол /ПЭ87051814/-д үйлдвэрлэлийн зориулалтаар 8 жилийн хугацаагаар тус тус шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ



Zax A/873 Ch  
02 04224